

МОНГОЛ-ОРОСЫН ХАРИЛЦААНЫ УЛАМЖЛАЛ БА ШИНЭЧЛЭЛ

*С.Дамдинсүрэн**

Монгол-Оросын харилцаа бол хүн төрөлхтний хөгжлийн хоёр дахь мянганы олон зууны ээдрээ нугачаатай цаг үеэ тусган эерэг, сөрөг шалгуурыг туулан эдүгээ хүрч ирсэн баялаг түүхтэй. Энэ харилцаа XIII зууны эхэнд Чингис хаан тэргүүтэй Их Монгол Улсаас дэлхийг түвшитгэн засах бодлогын хүрээнд явуулсан байлдан дагуулалт, дипломат болон худалдаа, эдийн засгийн үйл ажиллагаатай салшгүй холбоотойгоор үүсэн бүрэлдсэн. Чингис хааны бодлого бол аливаа улс орон, ард түмнүүдийг шудрага ёс, энхийг эрхэмлэсэн хүчирхэг төр, эрх зүйн нийтлэг дэг журам зарчмын хүрээнд шашин шүтлэг, итгэл үнэмшлээ хадгалан амьдрах хүн төрөлхтний түгээмэл эрх ашигт нийцснээрээ дэлхийг засан төвхнүүлэх эх ундрагатай байжээ. Харин байлдан дагуулалтын тухайд бол шудрага ёсыг тогтоохын тулд эцсийн арга хэмжээ болгон ашигласан нь тодорхой байдаг. Орос орон Монголын эрхшээлд оршиж байсан хоёр зуу илүү жил Оросын түүхэнд эерэг нааштай нөлөө үзүүлж дотоод улс төрийн тогтворгүй байдал, хямралдааныг зогсоох, нэгдсэн Орос улс байгуулагдах төрт ёсны зарчмуудыг төлөвшүүлэх, улмаар Орос их гүрэн болох таатай нөхцлийг бүрдүүлж өгчээ гэж хураангуйлан дүгнэж болох юм. Суурин ба нүүдлийн соёл иргэншлийг холбон, евразийн үзэл санааг тэтгэн дэлгэрүүлэх утгаар Монгол-Оросын харилцаа дэлхий дахины ач холбогдолтой.

Ардчилал, зах зээлийн харилцааны шинэ нөхцөлд түүхэн үнэнийг сэргээх чиглэлээр явагдсан эрдэмтдийн судалгааны үр дүнд урьд хаалттай байсан түүхийн сурвалж материал олноор нийтлэгдэн ил тод болж, бодит үнэнийг нээн харуулсан ном, хэвлэл элбэгшиж, урьд үзэл суртлын үүднээс хааж хорьсон ном бүтээлүүд ч олноор хэвлэгдэх болов. Энэ бүхэн Монгол-Оросын харилцааны мөн чанарыг гажуудуулан гуйвуулж үзэл сурталжуулан өрөөсгөлөөр тайлбарласан хуучин ойлголт үнэлэлтүүдийг няцаан шүүмжилж, шинэчлэсэн үнэн бодит санаа дүгнэлт өгснөөрөө онцлог юм. Орос орон Монголын талхигдал харгис ширүүн дарлал, зэрлэг аллага, хүчирхийллийг хүлээж байсан мэтээр тайлбарласаар ирсэн хуучин үзэл ойлголт нотолгоо үндэслэлгүй, хэт өрөөсгөл зүйл байсан нь нэгэнт тодорхой болов. “Орос орон Монголын талхидал дор оршиж” байсан гэдэг

*С.Дамдинсүрэн - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор (Sc.D), профессор

томъёоллоос анх татгалзсан эрдэмтэд гэвэл, Н.С.Трубешкой, Г.В.Вернадский, П.Н.Савицкий, Э.Хар-Даван зэрэг олон нэр тоочиж болно. В.Я.Владимирцов, В.В.Бартольд, Л.Н.Гумилев зэрэг алдар суут их эрдэмтэд Монгол Улсын түүх, Чингис хааны дэлхий дахины түүхэн үүргийг, хүн төрөлхтний соёл иргэншилд оруулсан хувь нэмрийг харуулсан бүтээлүүд нийтлүүлсэн юм. Харин ч тэр үед Монгол, Орос хоёр улс төр, эдийн засаг, соёлын талаар болон хүмүүнлэгийн, ураг садны холбоотой байсан нь харагддаг байна. Орост үзүүлсэн Монголын нөлөөний тухай асуудал олон талтай. Оросын вангууд Монголын их хааны болон Алтан Ордоны хааны эзэн эрхийг хүлээн дагаж алба төлдөг, өөрийн албат нараасаа цэрэг татаж Алтан Ордоны цэргийн албанд илгээдэг байсан. Монголчууд Оросын нутаг, хилийг халдлагаас хамгаалах, загалмайтны довтолгооныг таслан загсооход эергээр нөлөөлж байв.

Монголын эрх баригчид Оросын сүм хийдийг алба татвараас чөлөөлж өөр бусад эрх дарх өгч байсан нь үнэн алдарт шашин Оросын зүүн нутагт түгэн дэлгэрэхэд таатай нөлөөлсөн. Монголчууд олон улсын худалдаа хөгжүүлэхэд ихэд анхаарч дэмжиж байсны үрээр Монголын “ноёрхол” хэмээгчийн үед Оросын баруун орнуудтай хийх худалдаа ихэд хөгжсөн гэдэг.

Хүн төрөлхтөн хувь заяа нэгтэн мөнийг ухааруулж, дэлхийг түвшитгэн төвхнүүлэхэд чиглэсэн Чингис хааны үзэл санаа Ази, Европ хоёр тивийг холбож олон улс, үндэстэн, ард түмнийг эздүүлэн ойртуулахад таатай нөлөөлж байсны нэг жишээ бол бүр анхнаасаа үл дайсагнах үндэс суурь дээр байгуулагдсан Монгол, Оросын харилцаа байв.

Иймд энэ чиглэлээр судалгааг цаашид гүнзгийрүүлэн өргөжүүлэх явдал их ач холбогдолтой. Их Монгол Улс хүн төрөлхтний хоёр дахь мянганы нийтээр хүлээн зөвшөөрсөн гарамгай зүтгэлтэн Чингис хааны түүхэн үүргийг бодитойгоор үнэлж дэлхийн хөгжил дэвшилд хүчирхэг нөлөө түлхэц үзүүлсэн тэр их үйл хэргийн мөн чанарыг шинжлэх ухааны үүднээс судлан түүхэн үнэнийг сэргээх явдал ялангуяа түүхчид бидний чухал зорилго болж байна.

Чингис болон түүний залгамжлагчид Монголын ноёрхлыг Орост тогтоохын төлөө биш, харин хоорондоо хямралдан тэмцэлдэж байсан Оросын дотоодын хүчнүүдийг номхотгож Евразийг холбосон нэгдмэл улс гүрэн болон төлөвшихөд нь тус дөхөм үзүүлсэн ивээгчийн бодлого байсан нь тодорхой юм. Өөрөөр хэлбэл, Чингис хааны дэлхийг түвшитгэн төвхнүүлэх, олон улс, ард түмнийг эздүүлэн ойртуулах бодлогын салшгүй хэсэг байжээ.

Монгол-Оросын харилцаа түүхэн цаг үеийн эрхээр нэлээд завсарласны дараа XVII зууны эхэнд бие даасан бүрэн эрхт хоёр улсын харилцааны хэлбэрээр сэргэж эхэлсэн. Гэвч түүний мөн чанар, агуулга нь аажмаар, ялангуяа Монгол Улс Манжийн ноёрхолд орсноос хойш Их гүрний ноёрхлын шинж давамгайлах чиглэлээр өөрчлөгдөх болсон байна. Тэр үеэс Их Монгол Улсын үеийн олон улсын харилцааны холбон ойртуулах, эвлэлдүүлэн нэгтгэх, засан төвхнүүлэх, харилцан дэмжих уламжлал алдагдаж түүний шууд эсрэгээр булаан дээрэмдэх, колоничлон захирах, задлан салгах, хуваан эзэмших их гүрний бодлого улс хоорондын харилцааны чиглэлийг тодорхойлох болжээ.

Монгол нь олон улсын харилцааны бие даасан субъектээс Манж чин улс, Хаант Орос хоёр гүрний түрэлтэд шахагдан тэдгээрийн хуваан эзэмшиж байдаг олзны талбар болж хоёр зуу гаруй жилийг туулсан билээ. Энэ хугацаа нь хоёр том гүрэн Монголын нутаг дэвсгэрийг тасдан хувааж, хүн ардыг нь холдуулан салгаж, нэгдсэн загвартайгаар хөгжвөл зохих үйлдвэрлэхүй хүчнийг эвдэн бусниулж, соёл иргэншлийн үнэт зүйлийг нь салган сарниулж, түүнийг хүн төрөлхтөний хөгжил дэвшлээс ухраан хоцроосон хамгийн харанхуй он жилүүд байлаа.

Харин XX зууны эхэнд монголчуудын үндэсний ухамсар сэргэж 1911 онд Манжийн ноёрхлыг түлхэн унагаж Монголын тусгаар тогтнолыг зарлан тунхаглалат аанай л мөнөөх хоёр их гүрэн, шунахай сонирхолдоо хөтлөгдөн шамдан үгсэн хуйвалдсан юм. Тэгээд Монголын ихэнхи нутаг 1915 оны Хиагтын гэрээгээр түрэмгийлэгчдийн мэдэлд үлдэж багахан хэсэг болох Ар Монгол Хятадын эзэн эрхийн дор автономит болсон билээ. Энэ үеийн Монгол-Оросын харилцааны мөн чанар нь нэг талаар Хаант Оросын зүгээс Монгол Манжийн ноёрхлоос салж тусгаар тогтнолоо тунхаглахад дэмжлэг үзүүлсэн боловч, нөгөө талаар тэрхүү тусгаар тогтнолыг эвдэн Хятадын автономит хэсэг болгон хязгаарлах хоёрдмол бодлого баримталснаар тодорхойлогдож байна. Иймэрхүү хоёрдмол байр суурь Монгол-Оросын харилцаанд цаашид ч ул мөрөө хадгалсаар байсныг түүх бэлхнээ гэрчилмүй.

XX зууны үед улс төрийн нөхцөл байдал өөрчлөгдөхийн хэрээр Монгол-Оросын харилцааны шинж чанар ч өөрчлөгдөж тэр нь Монголын ард түмний эрх чөлөө тусгаар тогтнолын төлөө тэмцэл үндэсний ардчилсан хувьсгалын ялалт, Монголын нүүр царайг өөрчилсөн нийгэм, эдийн засаг, соёлын их бүтээн байгуулалтын чухал хүчин зүйл болсон билээ. Энэ хугацаанд БНМАУ олон улсын харилцаанд бие даасан субъектын хувьд хүлээн зөвшөөрөгдөж НҮБ-ын бүрэн эрхт

гишүүн болох зэргээр тусгаар тогтнолоо баталгаажуулахад хойт их хөршийн дэмжлэг шийдвэрлэх үүрэгтэй байлаа. Гэвч их гүрнүүдийн удирдагчдын 1945 оны Ялтын хэлэлцээрээр тогтоосон БНМАУ-ын статус-кво тусгаар тогтнолыг “одоогийн хилээр” нь баталгаажуулсан эерэг ач холбогдолтой хэдий ч Монголын хуваагдмал байдлыг ч давхар баталгаажуулсан хоёрдмол шинжтэй болсон юм. Монгол үндэстний хуваагдмал, саланги таслагдмал байдал нь монголчуудын соёл иргэншил, хөгжил дэвшлийн хүчийг сарниулан, монголчуудыг дэлхийн даяаршлын үйл явцад нэгдмэл хүчтэйгээр соёл, хүмүүнлэгийн үнэт зүйлээ нэгтгэн үр нөлөөтэй оролцон хамтын хувь нэмэрээ идэвхитэй оруулахад саад учруулагч таагүй хүчин зүйл болох нь улам тодорч байна. Үүнийг даван туулахад Монгол-Орос, Монгол-Хятадын харилцааг цаашид дэлхий дахины даяаршлын түвшинд нийцүүлэн монголчуудын соёл иргэншлийн нэгдмэл байдал, соёлын үнэт зүйлийг сэргээн идэвхжүүлэх чиглэлээр эрчимтэй хөгжүүлэх шаардлагатай.

Дэлхийн хөгжлийн даяаршил ба бүсчилэл гэсэн хоёр гол чиглэл хандлага нь улс орон бүрийн өмнө үндэсний эдийн засгаа тогтвортой, эрчимтэй хөгжүүлэх, олон улсын эдийн засгийн интеграцид оролцох чадавхиа шаргуу бүрдүүлэх шаардлагыг аяндаа тавьж байна. Ийм нөхцөлд баялаг уламжлалт харилцаа бүхий Монгол, Орос хоёр улс зах зээлийн харилцааны жам ёс, ардчилсан иргэний нийгмийн үзэл санааны дагуу, дэлхийн хөгжлийн чиг хандлагыг баримжаалан хамтын ажиллагаагаа сэргээж шинэчилэн хөгжүүлж байна. Түүхэн уламжлалын үүднээс ч, өнөөгийн хандлагын үүднээс ч, хоёр орны харилцаанд бүс нутаг, хил орчим, субъект хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэх нь нэн чухал чиглэлийн нэг болж байна. Манай хоёр улс сүүлийн үед энэ талаар тус тусын үзэл баримтлал боловсруулан их анхаарал, чармайлт тавьж байна. Энэ нь бодит зүй тогтол, учир шалтгаанар нөхцөлдсөн юм. Тухайлбал:

- Монгол, Орос хоёр улсын 3500 гаруй км нийтлэг хилийг бүхэлд нь хамарсан Сибирь, түүний субъектууд нь Монголтой геоэкологи, геоэдийн засаг, геополитикийн харилцан хамаарал ихтэй.

- Олон зууны турш нүүдлийн соёл иргэншлийг хамтдаа бүтээсэн угсаа гарал, хэл, соёл, ёс заншил, амьдрал ахуй ойролцоо ард түмнүүд зэрэгцэн оршиж үнэт зүйлсээ хуваалцаж ирсэн баялаг уламжлалтай.

- Харилцан нөхөх нөөц баялаг, хамтран ажиллах нийтлэг ашиг сонирхолтой.

- Дэд бүтцийн улам өргөжин тэлэх холбоо, харилцааны эх үүсвэртэй.

- Хоёр улс зах зээлийн харилцаанд нийцсэн нээлттэй бодлого явуулж, бүс нутаг, субъектуудын бие даасан санаачилгыг дэмжин хамтдаа хөгжих эрх зүйн таатай орчинг бүрдүүлэхийг тууштай зорьж байгаа.

- Таслан хуваагдаж, эвлэгдсэн үндэсний эв нэгдэл, соёлын үнэт зүйлээ сэргээн, хүн төрөлхтний нэгдмэл иргэншилд тив дэлхий, бүс нутгуудын олон улсын интеграцид хамтран оролцох боломж эрмэлзэлтэй, хувь нэмрээ оруулах чадвхитай.

Энэ бүхэнд манай харилцааны уламжлал ба шинэчлэлийн залгамж холбоо агуулагдаж байна. Үүнийг тээж явагч нь Монгол, Оросын найрсаг харилцааны баялаг уламжлалтай ард түмэн билээ.

Хоёр улсын бүс нутаг, хил орчим, субъект хоорондын хамтын ажиллагааны механизмыг бүрдүүлж, боловсронгуй болгох талаар эдүгээ хамтран хийж буй ажлууд, тухайлбал, худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан техникийн салбарт хамтран ажиллах Монгол, Оросын Засгийн газар хоорондын комиссын бүс нутаг, хил орчим, субъект хоорондын хамтын ажиллагааны Дэд комиссын үүрэг их ач холбогдолтой болж байна.

1997 онд анх байгуулагдсанаас хойш Дэд комиссын хэд хэдэн удаагийн хуралдааны хэлэлцэж шийдвэр гаргасан асуудлуудыг авч үзэхэд хоёр талын эрэлт сонирхлыг тусгасан механизмын хувьд нааштай төлөвшиж байгаа нь харагдаж байна. Үүнд дүрэм, программаа боловсруулахаас эхлээд шууд харилцаатай бүс нутгууд тодорхой субъектууд харилцан төлөөлөгчийн газар нээх, хилийн боомтуудыг төвхнүүлэх, субъект хоорондын хүч нөөцийг нэгтгэх, хилийн худалдааг хөгжүүлэх, хоршооллосон ажиллагаа, хамтарсан үйлдвэр байгуулах, тодорхой асуудлаар хамтарсан ажлын групп байгуулж, ажиллуулах санаачлага гаргаж янз бүрийн чиглэлээр харилцан айлчлал хийх гэх мэтээр Дэд комиссын ажиллагаа нэлээд өргөжих төлөвтэй. Энэхүү механизмыг цаашид улам боловсронгуй болгох удаа дараагийн хуралдаанаас гаргасан шийдвэрийг заавал биелүүлэх, тавьсан зорилгыг хэрэгжүүлэхэд хоёр талын идэвхи, оролцоог нэмэгдүүлэх, хамтын хяналтыг зохион байгуулах шаардлагатай.

Монгол, Оросын хил орчим бүс нутгууд, субъектуудын хамтын ажиллагааг нийгэм, эдийн засгийн өргөн хүрээнд идэвхжүүлэн хөгжүүлэх таатай нөхцөл, боломж бүрэлдэж, соёл хүмүүнлэгийн болон эдийн засгийн чиглэл давамгайлсан арга хэлбэр нь баяжсаар байна. Бүс нутаг, субъект хоорондын хамтын ажиллагаа зөвхөн хоёр талын үндсэн дээр төдийгүй, хэд хэдэн бүс нутаг, субъект хооронд олон талын үндсэн

дээр хөгжих таатай орчин бүрдэж байгааг Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулан авч үзэх нь чухал болж байна.

Бүс нутаг, хил орчмын хамтын ажиллагааг Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн зорилттой уялдуулахдаа хязгаар нутгийг хөгжүүлэх явдлыг тэргүүлэх зорилт болгож, төвийн бүс, нийслэл болон томоохон хотуудыг чиглэсэн хэт бөөгнөрлийг задлах, харин хязгаар нутгийн тархай бутархай хүч сарнимал байдлыг даван туулж тэнд орчин үеийн шинжлэх ухаан, технологийн ололттой холбогдох боломж бүрдүүлэх асуудалд төр засаг, олон нийтийн анхаарал зүй ёсоор татагдаж байгаа билээ. Үүний тул тэргүүн ээлжинд:

- Бүс нутаг нэг бүр болон түүний бүтцийн хэсэг бүрийн байгаль, эдийн засгийн нөөц баялаг, үйлдвэрлэл, оюуны хүч чадавхийг тодорхойлох үндсэн дээр хөгжлийн гол чиглэлийг нь нарийвчлан тогтоох;

- Бүс нутаг бүрийн тулгуур төвийг олон улсын төмөр зам, автозам, агаарын шугам, мэдээлэл, холбооны зангилаа газар болгож, эрчим хүчний төвлөрсөн системтэй холбон хоорондоо болон бүх бүрэлдэхүүн хэсгийг хамарсан нэгдсэн сүлжээнд оруулах. Гэхдээ бүс тус бүр нь нэг л тулгуур төвтэй байх;

- Монгол, Оросын бүс нутаг, хил орчмын харилцаа, субъектуудын хамтын ажиллагааг нийтлэг хилийн дагуух уугуул нутгаа хамтын хүчээр хөгжүүлж, хоёр ард түмний хэл, соёлын нэгдмэл байдлыг сэргээж үнэт зүйлээ баяжуулах аливаа урагшаа харсан эерэг хандлагыг хөхиүлэн дэмжиж, зааглан салгах хандлагыг агуулж байдаг хил-гаалийн үеэ өнгөрөөсөн дэглэм, визийн хязгаарлалт, зах зээлийн харилцааны нийтлэг жаягт харшилсан өндөр тариф зэрэг хойшоо чангаасан бүхнийг халж, улсын хилийг жинхэнэ эв нэгдэл, хөгжил цэцэглэлтийн зангилаа болгох;

- Монгол Улсын 5 бүс нутаг бүрийг баримжаалсан худалдааны ба эдийн засгийн чөлөөт бүс байгуулах, тухайлбал, Баруун бүсэд Цагааннуур, Хангайн бүсэд Эрдэнэт, Төвийн болон Улаанбаатарын бүсэд Алтанбулаг, Замын-Үүд, Зүүн бүсэд Чойбалсан хотууд байх бүрэн боломжтой. Үүнийг Үндэсний Хороо болон Бүс нутгийн Зөвлөлүүдийн эрх, үүргийн хүрээнд Засгийн газрын дэмжлэгтэйгээр хөрш болон түнш орнуудын оролцоотойгоор боловсруулан хэрэгжүүлэх;

- ОХУ-тай хил залгаа орших аймаг бүхэнд автозамын хил нэвтрэх боомт, чөлөөт худалдааны буюу бөөний худалдааны төвүүд байгуулах. Улирал бүхний онцлогт зохицсон үзэсгэлэн-худалдааг тогтмол графикаар зохион байгуулж хэвших;

- Бүсүүдийн гадаадтай эдийн засгийн талаар бие даан харилцах эрхийг өргөтгөж, гадаадын шууд харилцаатай бүс нутгууд, субъектуудтай хамтын ажиллагааг зохицуулах бүтэцтэй байх, харилцан төлөөлөгч солилцох, төлөөлөгчийн газар байгуулах гэх зэрэг;

- Мал бэлчээрээр хил давах, хулгайлагдах зэргээс үүдсэн зөрчил ихтэй Монгол, Тувагийн хил орчим нутагт зөвхөн хүчний байгууллагад түшиглэн тэмцэх төдийгүй, ард түмний амьдралыг дээшлүүлэх талаар аль аль талдаа анхаарах, мал аж ахуйн хамтарсан ферм, хоршоолол, мал эмнэлэг, үйлчилгээний газар, үйлдвэр байгуулах өргөн хэрэгцээний барааны бөөний худалдааны яармаг, үзэсгэлэн худалдаа тогтмол ажиллуулах, Тувагийн талын амьд мал импортлох сонирхлыг харгалзан малын арилжаа, худалдааны зах нээж, мал эмнэлэг, ариун цэврийн үйлчилгээтэй хосолсон сарын ажил зохиодог болох, мөн энэ үеэр мал маллагааны арга туршлага, зан үйл, ёс заншил, соёлын үнэт зүйлээ дээдлэн хүндэлдэг уламжлалаа сэргээн хөгжүүлэх олон талын ажил ч зэрэгцүүлэн явуулж байх;

- Бүс бүрийг олон улсын аялал жуулчлалын анхаарал сонирхол татахуйц онцлогоо тусгасан өвөрмөц бааз, маршруттай болгох;

- Улс орны эдийн засгийн хөгжлийн бүсчлэлд засаг захиргааны хуваарийг уялдуулан зохицуулах, тархай бутархай үрэлгэн бүтцийг өөрчлөх замаар улс орны засаг захиргаа, газар нутгийн хуваарьт тухайн бүс нутгийн эзлэх байр статусыг тодорхойлсон шинэчлэл хийх, одоогийн эдийн засгийн бүс тус бүрийг нэг аймаг буюу тойрог, одоогийн нэг аймгийг хушуу болгон, харин сумдыг засаг захиргааны анхан шатны нэгж болгож баггүйгээр засаг захиргааны хуваарийг боловсронгуй болгон зохион байгуулах нь зүйтэй санагддаг. Энэ бүхэн төсвийн зардлыг хэмнэх төдийгүй тархай, салангид хөдөө нутгийн эдийн засгийн хүч чадавхийг нягтруулж, хөгжлийн томоохон төслүүдийг хэрэгжүүлэх, ажлын байр бий болгон ядуурлыг бууруулж хөгжлийн бие даасан идэвхтэй хүчин зүйлийг бүрдүүлэх ач холбогдолтой болно.

- Бүс нутаг, хил орчмын хамтын ажиллагааны онцгой анхаарлын, нийтлэг ач холбогдолтой нэг асуудал бол байгаль орчин, экологийн жам ёсны харилцан хамаарлыг шинжлэн нээх, зохистой ашиглах, усны нөөц, экологийн цэвэр байдал, ургамал, амьтны бүтэц, зохицолдоог хамгаалах талаар хамтын ажиллагааны аливаа хөтөлбөр төсөлд заавал тусгаж байх, Монголын хөрснөөс ундран гарч буй гадагшаа урсан олдог гол мөрний усны нөөцөөс зохистой ашиглах, хавар, зуны үерлэлтийн үед усжуулах систем, нуур, цөөрөм, суваг байгуулах, ялангуяа ногоон

хэрмийн дагуу хүртэл усны хуримтлал бий болгох бодлого боловсруулах;

- Хоёр талын бүс нутгуудын хооронд хэлбэршин тогтож буй хамтарсан үйлдвэр, аж ахуйн газрууд, сургууль, боловсрол, соёл, урлагийн нийтлэг хэлбэрүүдийг улам дэмжин өргөтгөх, монгол угсаатан ард түмнүүдийн соёл урлагийн их наадам, монголчуудын иргэншил, монгол судлал, геологи хайгуул зэрэг шинжилгээ судалгааны болон эрдэмтэн, мэргэжилтэн, оюутан солилцох зэрэг идэвхтэй хэлбэрүүдийг улам хөгжүүлэх, Монголын талаас Оросын бүс нутгуудад хөрөнгө оруулалт хийж үйлдвэр, аж ахуй, сургууль, соёлын газрыг дагнасан буюу хамтарсан хэлбэрээр байгуулах талаар санаачилах;

- Бүс нутгийн хөгжлийн асуудлыг Засгийн газрын хөтөлбөрт санхүүжилтийг улсын нэгдсэн төсөв төлөвлөгөөнд тодорхой тусгаж байх;

- Бүс нутаг, хил орчмын субъектуудын харилцан суулгасан төлөөлөгчдийн газрын үйл ажиллагааг хооронд нь уялдуулах, нэгтгэн чиглүүлэх асуудлыг Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн талаар хамтран ажиллах Засгийн газар хоорондын комиссын дэргэдэх Бүс нутаг, хил орчмын хамтын ажиллагааны дэд комисст хариуцуулан зохицуулдаг болгож үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах нь зүйтэй гэж үзнэ.

Бүс нутаг, хил орчим, субъект хоорондын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх нь айл хөрш орнуудын хязгаар нутгуудын хоцрогдол, бөглүү байдал, ялангуяа Монгол мэтийн улс, үндэстний хувьд зааглан тусгаарлагдсан, таслан хуваагдсан ард түмний соёл иргэншлийн үнэт зүйлийн салгашгүй нэгдмэл чанарыг сэргээн, орчин үеийн шинжлэх ухаан технологийн ололттой холбон хүн төрөлхтний хөгжлийн нийтлэг гольдрол, дэлхийн глобал үйл явцтай хөл нийлүүлэх утгаараа улам өсөн нэмэгдэх ач холбогдолтой юм.